# АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2023 оны 3 дугаар сарын 27 Хэрлэн сум

Дотоод хяналтын албаны 2023 оны ажлын төлөвлөгөөний дагуу компанийн 2022 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийлээ.

Компанид Авлигатай тэмцэх газар болон “Онч Шийдэл” ТББ хамтран Төрийн байгууллага дахь авлигын эрсдэлийн үнэлгээг 2021 онд хийсэн. Тус эрсдэлийн үнэлгээгээр Авлигын эрсдэлийн ерөнхий нэгдсэн дүн-2.76 оноо буюу эрсдэлийн үнэлгээний **“Дунд”** түвшинд хамаарсан байна. Тус эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн сэдвүүдийг багцлан аудит хийхээр төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хариуцсан Эрх бүхий албан тушаалтанаар Бичиг хэргийн ажилтан Б.Маналжав ажиллаж байна. 2022 оны эхний 8 сард Хөдөлмөрийн харилцаа, хуулийн мэргэжилтан Д.Мэндсайхан ажилласан.

Компанийн 2022 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд 29 арга хэмжээг авч хэрэгжүүлж, 76 гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллахаар төлөвлөгөө гаргаж баталсан байна.

Тус төлөвлөгөөний биелэлтийг шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэж үзвэл:

Хангалттай буюу 100% гүйцэтгэлтэй шалгуур үзүүлэлт -24

Дунд зэрэг буюу 50% гүйцэтгэлтэй шалгуур үзүүлэлт- 8

Хангалтгүй шалгуур үзүүлэлт- 44 байна.

Дундаж гүйцэтгэлийг дүгнэж үзвэл **36.8%-** тай тус төлөвлөгөө биелсэн байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн дэлгэрэнгүйг хавсралтаар үзүүлэв.

## ДҮГНЭЛТ

Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилт “**Хангалтгүй”** байна. ЭБАТ тус төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах идэвх санаачлага гаргаж ажиллаагүй байна.

## ЗӨВЛӨМЖ

1. 2022 онд хийгдээгүй ажлуудыг хийж гүйцэтгэх, 2023 оны төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажиллах.
2. Эрх бүхий албан тушаалтанаар төлөвлөгөө гаргах, боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах ур чадвар бүхий ажилтан томилж ажиллуулах.

ТАНИЛЦСАН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ОТГОНБААТАР

ХЯНАСАН:
ДХА-НЫ ДАРГА Н.БААСАНПҮРЭВ

ТАЙЛАН БИЧСЭН:
ДОТООД ХЯНАЛТЫН АЖИЛТАН У.ЭНХЧИМЭГ

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

2023.03.27

| д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Биелэлт | Биелэлт /%-иар/ |
|---|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг байгууллагын ажилтнуудад сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх. | Хамаарал бүхий болон сонирхогч бүлгээс санал өгөх боломжоор хангах, шийдвэрлэх. | Хийгдээгүй. | 0% |
| | | Ил тод байршуулах техникийн нөхцөлийг бүрдүүлсэн байх/цахим хуудаст байршуулах/ | Компанийн цахим хуудас www.ees.energy.mn сайтад “ил тод байдал-авлигын эсрэг” цэсийг тогтмол байршуулан ажиллуулж байгаа ба тус цэснээс компанийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, АТГ-т шууд холбогдох, Авлигын талаар мэдээлэл өгөх утастай шууд холбогдох зэргийг нийтэд ил тод байршуулсан. | 100% |
| | | Нийт ажилтан, албан хаагчид болон бусад ААН албан байгууллагаас ирүүлсэн саналыг нэгтгэн танилцуулах. | Хийгдээгүй. | 0% |
| | | Эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, мөрдүүлэх арга хэмжээ авах. | Хийгдээгүй. | 0% |
| 2 | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг тогтмол мэдээллэх. | Холбогдох мэдээ мэдээллийг хуульд заасан хугацаанд хэрэгжүүлсэн байх. | Компанийн хэмжээнд www.shilendans.gov.mn сайтад холбогдох мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь оруулан ажиллаж байна. | 100% |
| | | Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтийг хангасан байх. | Компанийн хэмжээнд www.shilendans.gov.mn сайтад холбогдох мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь оруулан ажиллаж байна. | 100% |
| 3 | Байгууллагын дотоод сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангаж, ажилчдад мэдээллийг илтод, шуурхай хүргэж ажиллах | www.able.tog.mn дотоод сүлжээнд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт ажилчдын хэрэгцээний мэдээллийг шуурхай байршуулан мэдээлж байх. | Хийгдээгүй. | 0% |
| | | Дотоод сүлжээний системийг иж бүрнээр нь ашиглаж хэвших | Хийгдээгүй. | 0% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг хийж, мэдээллийн ил тод байдлыг хангах боломжийг бий болгох. | Компанийн цахим хуудас хэвийн ажиллагаатай байх. | Компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол цахим хуудсаар мэдээлж, мэдээлийн баяжилт хийгдэж байна. | 100% |
| | | Хэлтсүүдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээлж байх. | Хийгдээгүй. | 0% |
| | | Мэдээллийн баяжилт хийгдсэн байх. | Бүрэн хийгдээгүй. Үйл ажиллагаатай холбоотой мэдээ хийгдсэн. Бусад төрлийн болон авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийн баяжилт хийгдээгүй. | 50% |
| | | Цахим хуудасны мэдээлэлд санал хүсэлтийн хэсгийг оруулах, шийдвэрлэх | Хийгдээгүй. | 0% |
| | | Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг тогтмол хийх. | Хөгжүүлэлт тайлант хугацаанд хийгдээгүй | 0% |
| 5 | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хүрээнд мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ил тод байдлыг хангах. | Мэдээлэл нээлттэй, үр ашигтай, хүртээмжтэй байх. | Мэдээллийн нээлттэй байдал дунд, үр ашигтай, хүртээмжтэй байдал хангалтгүй. | 30% |
| | | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааны явцыг олон нийтэд тогтмол мэдээлж хэвшсэн байх. | Компанийн цахим хуудас болон орон нутгийн Дорнод сонин, Dornod телевизээр Эрчим хүчний хэмнэлт, цахилгааны аюулгүй байдлын талаарх заавар зөвлөмж, Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн талаарх мэдээ, мэдээллийг зурагт хуудас болон шторк хэлбэрээр бэлтгэн цахим орчинд иргэдэд сурталчилж ажилласан. | 100% |
| | | Байгууллагын цахим хуудас болон холбогдох бусад мэдээллийг цахим хуудсанд ил тод байршуулсан байх. | Хийгдээгүй. | 0% |
| 6 | Авлигын эсрэг үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах. | Шалгуур үзүүлэлт, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт ажилчдад танилцуулсан байх. | Хийгдээгүй. | 0% |
| | | Хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн байх. | Хийгдээгүй. | 0% |
| | | Шалгуур үзүүлэлтийг хангаж, үнэлгээнд хамрагдах | Хийгдээгүй. | 0% |
| | | Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байх. | Тайланг хавсаргав. | 100% |
| 7 | Компанийн бүтцийн нэгж дэх ажлын байр, албан | Нэр дэвшигчдийн ХАСУМ-ийг хүлээн авч, бүртгэх, | Э.Мөнх-Оргил, Ц.Цогзолмаа, Г.Төрмөнх, Р.Эрдэнэцогт, Т.Оюун нарын ХАСУМ-ийг хүлээн | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тушаалд нэр дэвшигчдийн ХАСУМ-ийг хүлээн авч бүртгэн, АТГ-т хүргүүлж хянуулж хариуг авах ажлыг зохион байгуулах. | | авч бүртгэсэн. | |
| | | АТГ-т хүргүүлэн хянуулах | Компанийн хэмжээнд 2022 онд ТУЗ-ын Хараат бус гишүүн Э.Мөнх-Оргил, 50 мвт-ын төслийн нэгжийн нягтлан бодогч Ц.Цогзолмаа, Сүхбаатар салбарын ахлах инженер Г.Төрмөнх, Сүхбаатар салбарын дарга Р.Эрдэнэцогт, ЗУХ-ийн дарга Т.Оюун нар АТГ-т ХАСУМ-ыг хянуулсан. | 100% |
| | | АТГ-аас ирүүлсэн ХАСУМ хянасан тухай албан бичгийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр байршуулах | Хийгдээгүй. | 0% |
| 8 | Мэдүүлэг гаргагч албан хаагчдаас хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсоноос хойш болон томилогдсоноос хойш 30 хоногт багтаан ХАСХОМ-ийг мэдүүлэх ажлыг зохион байгуулах. | Байгууллагын мэдүүлэг гаргагчид (шинээр томилогдсон) ХАМХОМ-ээ хуулийн хугацаанд гаргаж мэдүүлсэн байх. | Хийгдсэн. | 100% |
| | | Цахим системд баталгаажуулсан байх. | Хийгдсэн. | 100% |
| | | ЭБАТ-д цаасан хэлбэрээр мэдүүлгийг хүлээлгэж өгөх, ХАСХОМ-ын бүртгэлийг цахим системд оруулах | Хийгдсэн. | 100% |
| | | Мэдүүлэг бүрдүүлэлтийн ажил цаг хугацаандаа зохион байгуулагдсан, зөрчилгүй байх. | Компанийн хэмжээнд 2022 онд шинээр томилогдсон 5 ажилтанг шинээр бүртгэн ХАСХОМ-ыг гарган баталгаажуулан meduuleg.iaac.mn-д цаг хугацаанд нь бүртгэлд оруулан зөрчилгүй ажилласан. | 100% |
| 9 | Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх мэдэгдлийг холбогдох албан хаагчдаас гаргуулан авч, мэдүүлэг бүрдүүлэлтийн системд бүртгэх. | Холбогдох ажилтнуудаас мэдэгдлийг тухай бүр гаргуулан авах. | Хийгдээгүй. | 0% |
| | | Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд мэдэгдлийн мэдээллийг бүртгэн оруулсан байх. | Хийгдээгүй. | 0% |
| | | Мэдээллийн санг үүсгэн хяналт тавьж ажиллах. | Хийгдээгүй. | 0% |
| | Мэдүүлэг бүрдүүлэлтийн программ дахь "ЭБАТ" цэсний бүртгэлүүдийг тогтмол бүрэн хөтлөн мэдүүлэг, мэдэгдлийг хуулийн хугацаанд хүлээн авч, албан хаагчдад холбогдох зөвлөмж, арга | Хуульд заасан хугацаанд бүртгэл, бүрдүүлэлтийг хийж гүйцэтгэсэн байх. | Хийгдсэн. | 100% |
| | | Мэдүүлэг гаргагч албан хаагчдад хөрөнгө орлогод орсон тухайн жилд хамаарах их хэмжээний өөрчлөлтийг хуулийн хугацаанд мэдүүлэх талаар санамж өгөх. | Хийгдээгүй. | 0% |
| 10 | | Заавар, зөвлөмжийг холбогдох мэргэжилтэнд хүргэж, мэргэжил, арга | Компанийн хэмжээнд 2022 онд шинээр томилогдсон 5 ажилтанг шинээр бүртгэн заавар | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зүйн туслалцаа үзүүлэх. | зүйгээр хангаж ажиллах. | зөвлөмж өгч АТГ-т хүргүүлэн хянуулж ажиллав. | |
| 11 | Давхар ажил эрхлэлтэд тавих хяналтыг сайжруулах | Хуулийн холбогдох заалтыг хамаарал бүхий ажилтнуудад сурталчлан таниулах | Хийгдээгүй | 0% |
| | | Сургалт, семинар, холбогдох мэдээ мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах: | Хийгдээгүй | 0% |
| 12 | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, шийдвэр, албан бичгийн хэрэгжилтийг хангаж зохион байгуулалтын арга хэмжээ авах. | Удирдлага болон холбогдох албан тушаалтанд танилцуулан хэрэгжилтийг хангах. | 2022.10.28 06/14410 тоот албан бичгийн хариуг АТГ-ын ажилтанд хүргэж өгсөн. | 100% |
| | | Зөвлөмж шийдвэрийн хэрэгжилтийг гарган холбогдох удирдлага, олон нийтэд танилцуулах. | Хийгдээгүй | 0% |
| 13 | Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж, тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулах, тендерт шалгарсан, шалгараагүй үндэслэл, тендерийн үр дүнг худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д бүрэн оруулах, байгууллагын цахим хуудсанд тодорхой байршуулах. | Цахим хуудсанд тендерийн үр дүнг мэдээлэхдээ ХҮХ-ээр урьдчилсан хянуулсны дүнд олон нийтэд мэдээллэх | 2022 онд өөрийн хөрөнгөөр ДБЭХС ТӨХК нь НТШ-ийн 28, ХА-аар 32, ШХА-ийн 27, ШГБ-5 ажил буюу нийт 92 ажил төлөвлөж цахимаар буюу төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 100 хувь зарласан. Худалдан авах ажиллагааны үр дүнг цахим систем дээр цаг тухай бүрт нийтэлж, худалдан авахын төлөвлөгөө тайланг шиэлэн дансанд хугацаандаа байршуулсан. Эрчим хүчний яам болон холбогдох газруудад худалдан авах гүйцэтгэлийн тайланг хугацаандаа маягтын дагуу илгээсэн. | 100% |
| | | Цахим хуудаснаас мэдээллийг тодорхой авах боломжтой байх, | Хийгдсэн. | 100% |
| | | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байх, | Хийгдсэн. | 100% |
| | | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль болон Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын хэрэгжилт бүрэн хангагдсан байх. | Хийгдсэн. | 100% |
| 14 | Иргэдийн өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээлэл, олон нийтийн мэдээллийн | Өргөдөл(санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх(утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар, гм хэлбэрээр), | Өргөдөл гомдол санал хүсэлтийг хайрцаг, дэвтэрт, 70584771, 80584771, дугаар утсаар, “Хэрэглэгчдэд үйлчлэх төв Дорнод” фэйсбүүк хаягийн чат, “Хэрэглэгчдэд үйлчлэх төв ДБЭХС” пэйж хаягийн чатаар, dtog.mn сайтаар, bill center | 50% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэрэгсэл, цахим хуудсан мэдээлж хэвших. | | хэрэглэгчийн аппликшн, болон биеэр ирж бичгээр өгч байна. Нийт 371 өргөдлийг 100% шийдвэрлэж ажилласан. http://is.erc.mn/ Эрчим Хүчний Зохицуулах Хорооны тус сайтанд иргэдээс ирсэн өргөдөл гомдлын тайланг сар бүр 15, 30-р тасалбар болгож өгөгдсөн хүснэгтийн дагуу тайлант хугацаанд нь илгээж ажилласан | |
| | | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан ажилтны нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах, | Хийгдээгүй | 0% |
| | | Улирлын мэдээ гаргаж, шийдвэрлэлтийн байдлыг улирлаар мэдээлсэн байх, | Зөвхөн эрчим хүчний хэрэглээтэй холбоотой өргөдөл гомдлын мэдээ гаргасан. Бусад авлигын эсрэг үйл ажиллагаа болон ажилтны өргөдөл гомдолтой холбоотой мэдээ, шийдвэрлэлтийг мэдээлээгүй. | 50% |
| | | Цахим хуудсанд байршуулан мэдээлэх. | Хийгдээгүй | |
| 15 | Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр(тушаал, тогтоол)-ийг цахим хуудсанд байршуулах | Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх(цахим хуудсаар), | ТУЗ-ийн шийдвэр байршуулсан. Гүйцэтгэх захирлын тушаалыг байршуулаагүй. | 50% |
| | | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам , зааврыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байх | Хийгдээгүй | 0% |
| 16 | Авлигатай тэмцэх зорилго бүхий ТББ-ын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах | ТББ-ын үйл ажиллагааг дэмжих | Хийгдээгүй | 0% |
| | | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга (уриа, уриалга, мэдэгдэл, амлалт гм)-д нэгдэх | Хийгдээгүй | 0% |
| 17 | Авлигад өртөх эрсдэлтэй албан тушаал, | Судалгааны үндсэн дээр эрсдэлтэй ажлын байрны жагсаалтыг гаргах, | Хийгдээгүй | 0% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | үйлчилгээний жагсаалтыг гаргах. | Албан хаагчдаас санал авах, | Хийгдээгүй | 0% |
| | | Тушаалаар батлан гаргаж, байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээлэх. | Хийгдээгүй | 0% |
| 18 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар Үнэлгээний хороонд ажиллах төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллүүдэд уулзалт, семинар зохион байгуулах. | Уулзалт семинар зохион байгуулах | Хийгдээгүй | 0% |
| | | Хамтран ажиллах гэрээ байгуулах | Хийгдээгүй | 0% |
| | | Цахим хуудсанд холбогдох мэдээлэлийг байршуулах | Хийгдээгүй | 0% |
| 19 | Нийт албан хаагчдын авлигын эсрэг хууль тогтоомжийн ойлголт, мэдээлэл, холбогдох албан тушаалтнуудад мэдүүлэг, мэдэгдэл гаргах талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохон байгуулах. | Сургалтын сэдвийг АТГ-тай хамтран тогтоох, | Хийгдээгүй | 0% |
| | | Сургалтанд хамаарах албан тушаалтнуудыг хамруулах, | Хийгдээгүй | 0% |
| 20 | Шударга ёс, ёс зүйн асуудал хөндсөн сэдвээр сургалт, лекц зохион байгуулах. | Лекторыг сонгон холбогдож, лекц унших товыг тогтоох, | Хийгдээгүй | 0% |
| | | Лекцийг тогтсон хугацаанд уншуулах, | Хийгдээгүй | 0% |
| | | Нийт албан хаагчдыг хамруулсан байх. | Хийгдээгүй | 0% |
| 21 | Шинэ ажилтны сургалт болон сар, жилийн давтан зааварчилгааны сургалтын хуваарьт Авлигын эсрэг соён гэгээрүүлэх асуудлаар тусгаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. | Сургалтын сэдвийг ЭХЯ эсвэл АТГ-тэй хамтран тогтох, сургагч багш авах, | Хийгдээгүй | 0% |
| | | Сургалтад нийт албан хаагчдыг хамруулсан байх. | 2022 онд ажилд орсон шинэ ажилтнууд 2022.03.11 нд XXXМэргэжилтэн А.Мэндсайхан, 2022.10.18 ны өдөр XXXМэргэжилтэн Б.Солонго сургалт явуулсан/ хавсралт/ | 100% |
| 22 | АТГ-с бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, | -Холбогдох албан тушаалтанд танилцуулан биелэлтийг хангаж ажиллах. | АТГ-аас 2022 онд 5 албан тушаалтаны урьдчилсан мэдүүлэг хянаж ирүүлсэн. Өөр шийдвэр ирээгүй. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хариуг хугацаанд нь мэдэгдэх | | | |
| 23 | Нийтийн албанд томилгодохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг(ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох. | Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байх, | Хийгдээгүй | 0% |
| | | Байгууллагын цахим хуудсанд байршуулсан байх. | Хийгдээгүй | 0% |
| 24 | Ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлагыг баталсан байх. | Ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлагыг баталсан байх | Хийгдээгүй | 0% |
| | | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг шинэчилсэн байх. | Хийгдээгүй | 0% |
| 25 | Байгууллагын ажилтны ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцэх арга хэмжээ авах. | Байгууллагын ёс зүйн хорооны шийдвэрийн санг бүрдүүлсэн, тайлагнасан байх | Хийгдээгүй | 0% |
| | | Зөрчлөөс урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авсан байх | Хийгдээгүй | 0% |
| | | Өргөдөл гомдол, мэдээллийг хянан шалгах ёс зүйн хороо, хяналт шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүн сайжирсан байх. | Дотоод хяналтын албанд ирсэн ажилтны 1 гомдлыг хянаж Гүйцэтгэх захиралд танилцуулсан. Ёс зүйн хороо тус өргөдлийг хэлэлцэж шийдвэрлээгүй/ Жолооч Чингүүн/ | 50% |
| 26 | Аудит болон бусад мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | -Аудитын дүгнэлтийн хэрэгжилт сайжирч, зөрчлийг арилгасан байх. | 2022.09.30 нд 1/684 тоот албан бичгээр “Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит” ХХК-д хариу явуулсан. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна. | 100% |
| 27 | Худалдан авах үйл ажиллагааны тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх. | Тендерийн үйл ажиллагааг 100 хувь цахимаар явуулдаг болсон байх, | Хийгдсэн | 100% |
| | | Тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан | Хийгдсэн | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | төсөл, арга хэмжээг 100 хувь цахимаар зохион байгуулдаг, үр дүнг мэдээлдэг гүйцэтгэлийг холбогдох журмаар тайлагнах | | |
| 28 | Авлигын эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах. | Авлигын эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан байх, | Хийгдээгүй | 0% |
| | | Авлигатай тэмцэх газар болон гэрээт ТББ-тай хамтран ажиллах. | Хийгдээгүй | 0% |
| 29 | Эрчим хүчний яам, Авлигатай тэмцэх газар болон бусад дээд газраас ирүүлсэн авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх чиглэл, зөвлөмжийг тогтмол хэрэгжүүлэх. | -Зөвлөмжийг хэрэгжүүлсэн арга хэмжээ авсан байх. | АТГ-ын 2022 оны 01/14163 тоот зөвлөмжийн дагуу түүний хэрэгжилтийн байдлыг холбогдох материалын дагуу явуулсан. Хэрэгжилт хангалтгүй. | 50% |

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:
ДОТООД ХЯНАЛТЫН АЖИЛТАН У.ЭНХЧИМЭГ

ХЯНАСАН:
ДХА-НЫ ДАРГА Н.БААСАНПҮРЭВ